



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
“МОГОЙН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2026 оны 07 сарын 20 өдөр

Дугаар 01

Могойн гол

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус
хурлын тэмдэглэл

“Могойн гол” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал Хөвсгөл аймгийн ИТХ-ын хурлын танхимд 2026 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 15.00цагт зохион байгуулж хуралдаж эхэллээ.

“Могойн гол” ХК-ийн 829622 ширхэг энгийн хувьцаа бүхий 942 хувьцаа эзэмшигч хуралд оролцохоос 423119 ширхэг хувьцаа бүхий 3 хувьцаа эзэмшигч оролцож, тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд саналын эрх бүхий энгийн хувьцааны 51 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцож, компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.9 дэх заалтад шаардлагыг хангасан тул хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хүчин төгөлдөр болохыг тооллогын комиссын дарга танилцуулав. /Тооллогын комиссын тогтоолыг хавсаргав/.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд:

Хувьцаа эзэмшигч: 1. Д.Гэрэлчулуун-рү 53081014 -тэй Гүүдсекд бүртгэлтэй бширхэг хувьцаатай

2. Э.Долзодмаа-рү 60022302 Голомт капиталд бүртгэлтэй 6 ширхэг хувьцаатай

3. Хөвсгөл аймгийн ИТХ-9070591 регистртэй 423107 ширхэг хувьцаатай
Нийтдээ 423119 хувьцаа эзэмшигчид оролцлоо.

Хурлын дарга Г.Гандэлгэр: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Аймгийн ИТХ-ын даргын 2026 оны 06 сарын 10-ны өдрийн А/24 дугаартай Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тов тогтоох тухай захирамжийг танилцуулав.

Ц.Бэхбаяр: Саналын эрхтэй аймгийн ИТХ болон Засаг даргын удирдамж чиглэл томилогдсон орон нутгийн өмчийн төлөөлөл учир өөрийн эрх үүргийг танилцуулж бүртгэлээ хийлгэв. Ердийн гишүүнд нэр дэвшигч Г.Гандэлгэр, Ч.Хуншагай, Ц.Бэхбаяр нарыг танилцуулав.

Хувьцаа эзэмшигчид бүртгэлээ хийлгэхдээ иргэний бүртгэлийн лавлагааны дагуу хийлгэнэ. /emongolia-s/

Г.Өнөржаргал тархалтын судалгааны дагуу бүртгэлээ хийгээрэй.

Г.Гандэлгэр:Ээлжит бус хурал хуралдуулах тухай аймгийн ИТХ-ын албан бичгийг танилцуулав. Мөн Санхүүгийн зохицуулах хорооны албан бичгийг танилцуулав.

Ц.Бэхбаяр: Компаний шинэчлэгдсэн дүрмээр дийлэнх олонхиор, Хойшлогдсон хурал бол 33.3-р 4 сарын 29-нд хуралдах гээд ирц бүрдээгүй, Хойшлогдсон хурлыг 5 сарын 26-ны дотор хийх ёстой байсан.

Л.Батдэлгэр:Өмнөх хурлуудад хариуцлагагүй хандсан, 20 хоногийн дотор 51% нь оролцоод явах боломжтой байсан.

Ц.Бэхбаяр:Батболд гээд том төлөөлөгч ирээгүй учир ирц бүрдэхгүй болохоор боломжгүй болсон,Хойшлогдсон хурал хуралдуулах талаар албан бичиг хүргүүлсэн, ТУЗ 20 хоногийн дотор хурлаа зарлах байсан, 49 тал санаачлага муутай хандсан. Батдэлгэр ах та сайн мэдэж байгаа, тантай ч би ярьж байсан. Би 6 удаа сонгогдохдоо ийм юм болж байхыг хараагүй, ТУЗ-ын гишүүд бид компанид тус дэм байтугай бараг гай болж байгаа нь харамсалтай болж өнгөрсөн.Саналыг кумлятив аргаар заасан журмын дагуу явна.

Г.Гандэлгэр: Наадах асуудал 3 дугаарт байгаа учир хэлэлцэх үерээ ярилцаад явъя.

Л.Батдэлгэр:Хараат бусыг сонгоход өмнө нь хэлж байсан, хойшлогдсон хурлыг зөв явуулах байсан юм. Өнөөдөр хувь нийлүүлэгчид хурлаа хүндэтгээд ирсэн байх гэж бодсон.Тийм учраас би яриад байна 4 хувиас хараат бус гишүүнээ сонгоод явах боломжтой юу, хэрэв боломжгүй гэвэл бид оролцох шаардлагагүй, компанийн эрх ашгийг бодоод оролцож байгаа ч гэсэн хувьцаа эзэмшигч гэдэг утгаараа арай биш болчих гээд байна.ТУЗ-д ямар ч нөлөөгүй болчихно.

Ч.Гүнсэnnоров:Хараат бус гишүүдийг сонгох дээрээ ярилцах хэрэгтэй.

Ц.Бэхбаяр:Өнгөрсөн жил бол хэцүү байсан тэр яг давтагдах гээд байна.Хараат бус гишүүнийг сонгон шалгаруулахад нэг талын давуу байдал үүссэн, одоо үүнийг бид засаад явъя.

Л.Батдэлгэр: Тийм учраас би төрийн төлөөлөлийг 5 гишүүнтэй байлгаад явж болохгүй юу.

Г.Гандэлгэр:Энэ асуудал 3 дахь асуудал юм, та бүхэн хараат бус дээрээ тохироол явъя гээд байх шиг, өмчийн төлөөлөл бол удирдамжтай байгаа түүнийгээ хэрэгжүүлээд явна.

Ч.Гүнсэnnоров:Би нэг юм асууя, жижиг хувьцаа эзэмшигчид хохироод яваад байна. Компанийн үйл ажиллагаа доголдож байхад төр төлөөлсөн хүмүүс өчнөөн цалин аваад хурлаа хугацаанд нь хийчиж болоогүй юм.

Ц.Бэхбаяр: Энэ талаар өмнө нь хэлсэн.Тооцоо хийсэн том хувьцаа эзэмшигчид ирэхгүй бол 331 хүнээ цуглуулаад ч 67% хүрэхгүй,

Г.Гандэлгэр: Ийм учраас Өнөржаргалд хүргүүлсэн, дийлэх олонхи гэдэг бол 67% юм.Хүчингүй болох хурал руу очих боломжгүй юм.

Одоо ирцээ танилцуулсан, ирц хүрсэн учир төлөвлөгөөг батлуулья.

Л.Батдэлгэр: Асуудлаа тохирч авчихаад цаашаа явахгүй бол үр дүнгүй болчих вий, шүүх дээр очдог зөрчсөн юм болчих вий.

Ц.Бэхбаяр: Хууль дээрээ бичсэн зүйлээ л барихгүй бид өөр яах юм бэ. 69.9 дээр бол байгаа. 50+1ээрээ ирцээ тооцно гээд заагаад өгсөн.

Л.Батдэлгэр: Одоо ирц нь хүрэхээр байгаа юм уу.

Ц.Бэхбаяр: Хуулиараа хүрч байгаа.

Л.Батдэлгэр: Бэхбаяртай 5 минут гарч уулзчаад ирье.

Г.Гандэлгэр: Та уулзалт хийчихээд хуралд суух эсэхээ шийдэх гээд байна уу. Таны хараат бус гишүүнд оруулах гэж байгаа хүн энэ жагсаалт дотор байгаа байх.

Л.Батдэлгэр: За яахав ээ ирц нь хүрээд явж байгаа бол.

Ц.Бэхбаяр: Та нэг хүний талаар ярьж байсан, компанид хэрэгтэй хүн гээд.

Л.Батдэлгэр: Тиймээ тийм. Чиний удирдамж юу юм бэ.

Ц.Бэхбаяр: Би удирдамжаа дэлгэмээргүй байна.

Г.Гандэлгэр: За тэгвэл 3 дахь асуудлын өмнө та 2 уулзчих уу.

Хэлэлцэх асуудлыг танилцуулав.

Ч.Гүнсэнноров: Үе үеийн ТУЗ-ийн гишүүд компанийн хөрөнгөөр нааддаг харамсалтай санагддаг.

Г.Гандэлгэр: Бидэнд хувийн эрх ашиг гэж байхгүй шүү, та хамаагүй ингэж ярьж болохгүй. Хөвсгөл аймгийн өмч хөрөнгийн төлөөлөл болж сууж байгаа хүмүүс. УИХ-ын байнгын хорооны 2024 оны тогтоолтой. Та бүхэн хуралдаа суугаад оролцоод яваач гэж хэлмээр байна. Хараат бус гишүүний өмнө нь 6 дараа нь 5 хүний материал ирсэн 2 хүнийх давхардсан, нийтдээ бүх 9 нэр дэвшигчдийг жагсаалтад оруулж та бүхнээр хэлэлцүүлнэ. Та бүхэн саналаа өгөөд явна.

Л.Батдэлгэр: Би тодорхой саналаа хэлсэн 4 % хүлээн зөвшөөрөгдөх үү гэж. Ирц нь бүрдэж байгаа бол өөрсдөө мэдээд нэрээ дэвшүүлээд яв, бид явья даа.

Г.Гандэлгэр: Хэлэлцэх асуудлын дарааллын дагуу Ц.Баттогтох захирал мэдээллээ хийгээрэй.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Могойн гол ХК-ийн 2025 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн дүгнэлт

Асуудал оруулсан "Могойн гол" ХК-ийн гүйцэтгэх захирал Ц.Баттогтох:

Компанийн үйл ажиллагааг хэвийн явуулах гэж олон талаар ажиллаж байна. 17 тэрбумын өртэй, дансандаа мөнгөгүй бараг харьцдаг бүх байгууллагад өртэй, нийтдээ 159 хүнтэй компанийг хүлээн авсан, Гандэлгэр даргатай болон ТУЗ-ийн гишүүдтэй ярилцаж, боловсон хүчний зохион байгуулалтыг хийсэн. 106 хүнтэй болсон. Шүүх дээр 6 компани авлагатай гээд нэхэмжлэл гаргасан явж байна, ШШГГазраас данс барьсан байгаа. Бид хүсэлт гаргасан боловч боломжгүй гэсэн хариуг өнөөдөр олж авсан. Энэ дээр одоо яах вэ. Манай дээр одоо бол өмнөх жилийг

бодоход үйл ажиллагаа боломжтой байна.40000 гаруй тонн нүүрсийг бэлэн цагаалаад бэлдсэн, харилцах дансанд 415,0сая төг бэлэн байгаа, 6 сарынхаа цалинг тавьчих боломжтой боловч данс хаагдсан учир гүйлгээ хийх боломжгүй байна.Үйл ажиллагааны хувьд орон нутгаас дэмжлэг их авч байгаа учир яваад л байна, авлагаа авна, нүүрсний үнээ урьдчилгаа байдлаар авах, өвлийн бэлтгэлээ хангаад явах төлөвлөлт зохион байгуулалтаа хийгээд явахад хүндрэлүүд гарч байна.4,8 тэрбумын борлуулалт хийсэн байгаа.Нийгмийн даатгал болон 100,0саяас доош бүх өрийг төлсөн. Тосон энержид өгөх нүүрсээ өгсөн ,бүтэн жил хүндрэлтэй байдалтай явж ирсэн.ТУЗ хуралддаггүй, шийдвэр гаргаж өгдөггүй,өмнө нь харьцаж байсан хэлтэс агентлагын дарга нар нааштай хандаж зохицуулж өгч байдаг. Бид борлуулалтаасаа 7 орчим тэрбум төгрөгийн өглөгийг төлж барагдуулсан.Гэвч НӨТ болон АМНАТ-ын татвар нөгөө талаар өсөөд байдаг. 5сарын 13ны байдлаар Эмралд ХХК нэхэмлэлийн шүүхийн шийдвэрийн дагуу данс хаасан. Гэвч 3 дагч этгээдийг хохироож болохгүй гэсэн заалт байгаа тэр нь манай ажилчид бөгөөд түүнийг тайлбарлаж хэлэхээр хүлээн зөвшөөрч байгаа боловч шийдэлд хүрэхгүй байна.Компанийн ажлын хажуугаар шүүхийн ажил ихтэй байна, Түрээсээр техник ашиглуулахаар манайд орж ирэхгүй байна./танилцуулсан материалыг хавсаргав/

Г.Гандэлгэр:Аймгийн онцгой бүс гэдэг утгаараа ЗГ-т хандах боломжтой, өнөөдөр Учрал ерөнхий сайд , аймгуудын Засаг дарга нартай өвөлжилтийн бэлтгэл ажлын талаар цахимаар хуралдсан, маргааш ЗГ хуралдана гэсэн.Энэ талаар асуудлаа Засаг даргад танилцуулаад уламжлая.

Ц.Баттогтох:Энэ талаар өмнө нь хандаж байсан, холбогдох хүмүүс ирсэн боловч ямарч шийдэлд хүрээгүй.Одоо 55 хоногийн дараа галлагаа эхэлнэ.

Г.Гандэлгэр:Одоо бол ТУЗ зөвхөн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулахаар байгаа. Энэ хурлын төлөвлөгөөнд Компанийн 2025 оны ногдол ашиг хуаарилах эсэх талаар орох байсан орхигдсон байна, энэ талаар ямар саналтай байна.

Ц.Баттогтох:Үйл ажиллагаа доголдолтой байгаа учир ногдол ашиг хуваарилах боломжгүй байхаар байна.

Ц.Бэхбаяр:Компанийн үйл ажиллагааг хангалттай гэж үзэж байна. Ногдол ашиг хуваарилахгүй байх талаар тэмдэглэлдээ тусгаад явья.

Э.Долзодмаа:Өмнө нь хянаагүй юм уу, яагаад ингээд өрөнд оруулсан юм болоо,Баттогтох захирал бол өөд ньтатах нь ойлгомжтой, ШШГГ-ын бичгийг хойшлуулж болохгүй юу.Үнэлгээг хангалттай гэж үзэж байна.Ногдол ашиг хуваарилах боломжгүй юм байна гэж ойлголоо.

Б.Гэрэлчулуун: Компанийн үйл ажиллагааг хангалттай сайн гэж үнэлж байна.Ногдол ашиг хуваарилах боломжгүй гэж сая тайлангаас ойлголоо.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1.Могойн гол ХК-ийн 2025 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хэлэлцээд “ Хангалттай” гэж дүгнэв.

2."Могойн гол"ХК-ийн 2025 оны ногдол ашиг хуваарилахгүй байхаар олонхийн саналаар дэмжив.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

2. Могойн гол ХК-ийн ТУЗ-ийн 2026 оны зардал батлах тухай.

Асуудал оруулсан Г.Гандэлгэр:

Энэ оны ТУЗ-ийн зардлыг өмнөх онтой ижил байдлаар тусгасан. 2025 оны 5 сараас хойш зөвхөн цалингийн зардал гарсан, өөр ямар нэгэн зардал гаргаагүй хэмнэж ажилласан. Өмнө нь ямар байсныг мэдэхгүй. 2025 оны ТУЗ-ын зардлыг гүйцэтгэлээр нь гаргаж өгөөрэй нягтлан Дэлгэржаргал ТУЗ үйл ажиллагааны хувьд хэвийн ажиллах боломжгүй байсан, төр төлөөлсөн Зхүн байгаад ирц бүрдэхгүй байсан хүндрэлтэй байсан.

Ц.Бэхбаяр: Аудитын дүгнэлтийн дагуу төсвөө батлаад явъя.

Бусад орлоцогчид бүгд дэмжив.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Могойн гол ХК-ийн ТУЗ-ийн 2026 оны зардал батлах тухай тогтоолын төслийг дэмжив.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

3. Могойн гол ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай Асуудал оруулсан Г.Гандэлгэр:

Төрийн төлөөлөлд 1. Ч.Хуншагай, 2. Ц.Бэхбаяр, 3. Г.Гандэлгэр, Ё.Батсайхан нар орохоор холбогдох шийдвэр санал ирүүлсэн. Хараат бус гишүүнд өмнө ирсэн хүсэлтээ ирүүлсэн 6, сүүлд 5 хүний материал ирсэн, Н.Нэргүй, Г.Баярсайхан гэсэн 2 хүний материал давхардаж ирсэн нийтдээ 9 хүний нэрийг оролцуулаад явъя.

Ц.Бэхбаяр: 9 хүний нэрийг кумулятив аргаар сонгоод явах саналтай байна. Л.Батдэлгэр гишүүн өөрсдөө мэдээд нэрээ дэвшүүлээд яв гэсэн учир төрийн төлөөлөлд Ё.Батсайханыг оруулах саналтай байна. Бид нэр дэвшүүлэх хороо биш учир өмнөх ирсэн хүмүүсийг оролцуулаад нийтдээ 9 хүнээс сонгоё. 5%-иас дээш хувьцаатай хувьцаа эзэмшигчийг нэр дэвшүүлэх саналтай байна.

Г.Гандэлгэр: Тооллогын комисс ажилдаа ороорой.

Г.Өнөржаргал: Тооллогын комиссын дарга:

Та бүхэнд санал хураалтын дүнг танилцуулья.

1. Компанийн 2025 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хангалттай гэж 423119 ширхэг санал, татгалзсан 0 санал, түдгэлзсэн 0 санал өгч компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг Хангалттай гэж дүгнэв.

2. ТУЗ-ийн 2026 оны зардлын төсвийг 423119 ширхэг санал, татгалзсан 0 санал, түдгэлзсэн 0 санал өгч 100 хувийн саналаар батлав.

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгоход нийт 423119 ширхэг хувьцааны саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид оролцсон бөгөөд кумулятив аргыг ашиглаж доорх саналыг өгсөн байна. Үүнд:

№	ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн овог нэр	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
Ердийн гишүүн		
1	Г.Гандэлгэр	634616
2	Ц.Бэхбаяр	634616
3	Ч.Хуншагай	634610
4	Ё.Батсайхан	634610
5	Ж.Батболд	132
6	Н.Батдорж	130
Хараат бус гишүүд		
1	Б.Нямдаваа	423107
2	Э.Даваачулуун	423122
3	Ч.Оюунчимэг	423107
4	Б.Дорждагва	15
5	Г. Баярсайхан	0
6	Н.Нэргүй	6
7	Б.Түмэндэлгэр	0
8	Д.Мөнхбат	0
9	Л.Амарболд	0

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1.Компанийн 2025 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хэлэлцээд Хангалттай гэж дүгнэв.

2.ТУЗ-ийн 2026 оны зардлын төсвийг 100 хувийн саналаар батлав.

3.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг дараах бүрэлдэхүүнтэй сонгов. Үүнд:

1. Г.Гандэлгэр (634616 ширхэг санал)
2. Ц.Бэхбаяр (634616 ширхэг санал)
3. Ч.Хуншагай (634610 ширхэг санал)
4. Ё.Батсайхан(634610 ширхэг санал)
5. Ж.Батболд (132 ширхэг санал)
6. Н.Батдорж(130 ширхэг санал)

Хараат бус гишүүнд:

- 1.Б.Нямдаваа (423107 ширхэг санал)
2. Э.Даваачулуун (423122 ширхэг санал)

3. Ч.Оюунчимэг (423107 ширхэг санал) нарыг дэмжиж батлав


Хурал 18:30цагт дууссан.

ДАРГА

ХЯНАСАН:

Г.ГАНДЭЛГЭР

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

“МОГОЙН ГОЛ” ХК-ИЙН ТУЗ-ИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Э.ДАВААЧУЛУУН